



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Empowered lives.
Resilient nations.

“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

2020 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2020 оны 11 дүгээр сар

Улаанбаатар хот

ТӨСЛИЙН ТУХАЙ

Тайлан хамарч буй хугацаа	2020 оны 1 дүгээр сар-11 дүгээр сар
Төслийн дугаар	МОН/17/101
Төслийн нэр	“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
Төсөл хэрэгжиж эхэлсэн огноо	2017 оны 1 дүгээр сарын 01
Төсөл хэрэгжиж дуусах огноо	2020 оны 12 дугаар сарын 31
Төслийг хамтран хэрэгжүүлэгч	Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБХХ
Төслийн төсөв /нийт/	3,800,000 ам.доллар
Санхүүжилт	ШХА 3,135,000 швейцар франк НҮБХХ 500,000 доллар
<p>НҮБХХ-ийн улс орны хөтөлбөрийн холбогдох үр дүн: 2021 гэхэд засаглалын байгууллагууд залуучуудын үр нөлөөтэй оролцоог хангаж, ядуу, эмзэг бүлгийн эрхийг хамгаалан, иргэдийн өмнө хүлээх хариуцлага дээшилнэ.</p> <p>Төслийн хүлээгдэж буй үр дүн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байна. 2. ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байна. 3. Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна. 4. УИХ-ын Тамгын газраас төлөөллийн байгууллагад дэмжлэг үзүүлэх чадавх дээшилсэн байна. 	
2020 оны төсөв	750,000 доллар
2020 оны төсвийн гүйцэтгэл (11 дүгээр сарын байдлаар)	430,000 доллар

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага

АГУУЛГА

Товч.....	5
ХҮРЭХ ҮР ДҮН 1: Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байх	6
ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байх	9
ХҮРЭХ ҮР ДҮН 3: Орон нутгийн сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох	15
ХҮРЭХ ҮР ДҮН 4: Сонгогдсон Төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ-ын Тамгын газрын чадавх сайжирсан байх	19
Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж	26
Төслийн санхүүгийн менежмент	27

2020 ОНД БИЙ БОЛСОН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сард оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Засаг захиргаа, нутаг дэвсгэртэй холбоотой хэд хэдэн өөрчлөлт орж, тэдгээрт нийцүүлэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, өргөн барьсан бөгөөд Улсын Их Хурлаар хэлэлцэж эхлэв.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд олон нийтийг цуглуулсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх, гадаад, дотоодод зорчихыг хориглосон шийдвэр гарсан тул төслийн хүрээнд төлөвлөгдсөн зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болж, сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа.

Орон нутгийн ээлжит сонгууль 2020 оны 10 дугаар сард явагдаж, шинээр бүрэлдсэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд анхдугаар хуралдаанаа хийв. Өмнөх сонгуулиудтай харьцуулахад анх удаагаа хоёр аймгийн ИТХ-ын төлөөлөгчид даргаараа эмэгтэй Төлөөлөгчийг сонгожээ. Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн 70 гаруй хувь нь анх удаа шинээр сонгогдсон төлөөлөгчид байна. Бусад нэгжийн ИТХ-ын анх удаа шинэ сонгогдсон төлөөлөгчдийн тоо, эмэгтэйчүүд, залуучуудын эзлэх хувийн талаарх мэдээллийг судлах, нэгтгэх ажил хийгдэж байна.

ХҮРЭХ ҮР ДҮН 1: НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРСАН БАЙХ

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын (ЗЗНДНТУХ) тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бэлэн болж, УИХ-аар хэлэлцэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сард Засаг захиргаа, нутаг дэвсгэртэй холбоотой томоохон өөрчлөлтүүд орсноор дээрх хуулийн төслийг Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй нийцүүлж, дахин боловсруулах шаардлага үүссэн.

Иймээс ЗЗНДНТУХ-ийн хэрэгжилтийн байдалд судлаачдын хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан, 2017-2019 онуудад зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, чуулганы үеэр гарсан саналуудыг тусган Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлэв. Энэ хүрээнд 2020 онд дараах ажлууд хийгдлээ:

- Хуулийн төсөл санаачлагч УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, Н.Амарзаяа, Ё.Баатарбилэг, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Ганболд, Д.Лүндээжанцан, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар нарын дэмжин баталсан үзэл баримтлалын дагуу нутгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаачдын баг хуулийн төслийг шинэчлэн боловсруулав. Ингэхдээ 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн төрийн байгууламжийн талаарх суурь үзэл санаа, Дөрөвдүгээр бүлэг, мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэл болгож боловсрууллаа (ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг хавсралтаас үзнэ үү).
- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран ЗЗНДНТУХуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар хэлэлцүүлгийг 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх Ж.Сүхбаатар, нутгийн удирдлагын эрх зүйн орчны талаар судалгаа, шинжилгээ хийдэг эрдэмтэн, судлаачид, хуульчид, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны Ажлын албаны ажилтнууд оролцов.



- УИХ-аас байгуулагдсан Төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг судалж дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг 02 дугаар сарын 18-ны өдөр эрдэмтэн судлаачдыг оролцуулсан өргөтгөсөн бүрэлдэхүүнээр хуралдаж, ЗЗНДНТУХ-ийн

шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга, үзэл баримтлалын төслийг дэмжин сайшаав.

- ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг Д.Тогтохсүрэн, Н.Амарзаяа, Ё.Баатарбилэг, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Ганболд, Д.Лүндээжанцан, Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар нарын УИХ-ын гишүүд 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр УИХ-ын даргад өргөн барив (<http://www.parliament.mn/n/q9mo>). УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 28, УИХ-ын чуулганы 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар тус хуулийн төслийг хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн. Шинэчилсэн хуулийн төсөлд орон нутаг дахь улс төржилтийг зогсоох үүднээс ИТХ-д улс төрийн намын бүлэг байгуулахыг хориглох, сумын Хурлын сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй байх, бусад Хурлын хувьд нэр дэвшүүлсэн нам нь төлөөлөгчөөр сонгогдсон гишүүндээ үүрэг хүлээлгэхгүй байх зэрэг зохицуулалтууд орсныг УИХ-ын гишүүд хэлэлцүүлгийн үеэр онцолж байв. Мөн орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, орон нутгийн өмчийн удирдлага, төсөв, татвар, төлбөр, хураамжийг тогтоох, эрүүл мэнд, нийгэм соёлын зэрэг асуудлаар бодлого тодорхойлж хэрэгжүүлэх гэх мэт тодорхой чиг үүргийг шилжүүлэх замаар иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн зохицуулалтуудыг УИХ-ын гишүүд дэмжиж байв¹.



- Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Нээлттэй Нийгэм Форумтай хамтран иргэний нийгмийн байгууллагуудын дунд 5 дугаар сарын 8-нд цахимаар хэлэлцүүлж, 13 төрийн бус байгууллага оролцов. Хуулийн төсөлд нэг удаагийн болон хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргуулахаар санаачлах, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр санал дэвшүүлэх зэрэг иргэдийн оролцоог баталгаажуулсан зохицуулалт тусгасан, нэгжийг орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршилд тулгуурлан өөрчлөн зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн, нэгж тус бүрийн чиг үүргийг тодорхой болгон заагласан нь чухал ач холбогдолтой байна гэж ИНБ-ууд үнэлсэн байна. Тус хэлэлцүүлгийн дүн Нээлттэй Нийгэм Форумтаас эрхлэн гаргадаг “Хуулийн шүүмж” цувралын №30 дугаарт нийтлэгдэн олны хүртээл болж байна.


¹ УИХ-ын албан ёсны цахим хуудас, www.parliament.mn


- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академитай хамтран Нутгийн удирдлагын сургалт, судалгаа, мэдээллийн төвөөр дамжуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх цахим хэлэлцүүлгийг 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны Ажлын алба, ЗГХЭГ, Удирдлагын академи, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, 15 аймгийн ИТХ болох ЗДТГ-ын төлөөлөл зэрэг нийт 30 гаруй хүн оролцож, саналаа танилцуулав.
- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг /ахлагч УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар/-тэй хамтран 8 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт хууль санаачлагч гишүүдийн төлөөлөл, ажлын хэсгийн гишүүдээс гадна УИХ-ын зарим гишүүд, нийслэл, аймаг, сум, дүүргийн удирдах байгууллагын холбогдох албан тушаалтнууд, салбарын эрдэмтэн судлаачид, олон улсын төсөл, төрийн бус байгууллагын төлөөлөл болох 60 гаруй хүн оролцов.

“Энэ хуулийн төсөл нь орон нутгийн иргэдэд үйлчлэх учиртай. Монгол Улсын хүн ам нутаг дэвсгэрээ яаж засаглах вэ гэсэн асуудалд амин сүнс нь байгаа. Уг хуулийн төсөлд анх удаа орон нутгийн чиг үүргийг нэгж тус бүрээр тодорхойлох, төрөөс орон нутгийн удирдлагад шилжүүлэх, шилжүүлж үл болох эрх мэдлийн жагсаалтыг шинээр тусгаж, чиг үүргийг аль болох иргэдэд ойр нэгжид хуваарилан, санхүүжилтийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх зарчмыг баримталснаараа үнэ цэнэ нь оршиж байна.”

Хэлэлцүүлгийг хааж, УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатарын хэлсэн үг..

- ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг 8 дугаар сард болсон УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэж сэн боловч Ардчилсан намын бүлэг завсарлага авсан тул хойшилж, намрын чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэж байна.
- Нутгийн удирдлагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж буй өөрчлөлтийг олон нийтэд таниулан мэдээлэх сурталчлах ажлууд хийгдлээ. Тухайлбал, хууль санаачлагч болон хуулийн төсөл боловсруулагчид оролцсон телевизийн ярилцлага орон даяар цацагдав. Түүнчлэн, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, онцлох асуудлын талаар инфографик ном бэлтгэн нийт аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ-т хүргүүлэв.





Дээрх зохион байгуулагдсан үйл ажиллагааны үр дүнд болон ном, гарын авлага, судалгаа мэдээллүүдийг боловсруулж түгээснээр холбогдох талуудын нутгийн удирдлагын талаарх мэдлэг, туршлагад томоохон ахиц өөрчлөлт гарсан гэж үзэж болох юм.

ХҮРЭХ ҮР ДҮН 2: ИТХ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ

Төслөөс боловсруулсан хуралдааны үлгэрчилсэн дэг ИТХ-уудын үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлснээр хуралдааны үйл явц илүү боловсронгуй, иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудад нээлттэй болж байна.

2020 оны эхний 7 сарын байдлаар ИТХ-ын үлгэрчилсэн дэгийг ашиглан аймгийн ИТХ-ын 18.8%, сумын ИТХ-ын 23.8% нь тус тус хуралдааны дэгээ шинэчлэн боловсруулж батлуулсан. Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуулиар бүрэлдсэн Хурлуудад үлгэрчилсэн дэгийг танилцуулах, батлуулах бэлтгэлийг хангах зорилгоор 9 дүгээр сарын 9-ний өдөр аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажилтнуудтай цахим хэлэлцүүлэг хийв. Үүний үр дүнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Ховд зэрэг аймгийн ИТХ анхдугаар хуралдаанаараа дэгээ шинэчлэн баталсан бөгөөд бусад аймгуудын хувьд дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд оруулаад байна. Түүнчлэн аймгийн ИТХ-ын Ажлын албад сумдын ИТХ-ууддаа дэгийн төсөл боловсруулахад нь зөвлөмж өгч ажиллаж байна. Ингэснээр 2020 оны 10 сарын байдлаар нийт аймгийн ИТХ-ын 48 хувь нь шинэчлэгдсэн дэгийг батлан мөрдөж байгаа юм. “ИТХ-ын үлгэрчилсэн дэгийн дагуу хуралдааны дэгээ шинэчлэн баталсны үр дүнд өмнө нь хоёрхон хуудас байсан дэг маань одоо бараг 20 хуудас болж, олон нарийн асуудлуудыг зохицуулахад тус дөхөм болж байна. Тухайлбал өмнө нь дэгийг хуралдааны үеийн л асуудал гэж хардаг байсан бол үлгэрчилсэн дэгийн дагуу хуралдаан зохион байгуулах бэлтгэлтэй холбоотой асуудлыг мөн тусгаснаар илүү бэлтгэлтэй, зохион байгуулалттай хуралдаан хийдэг болоод байна” гэж Дорноговь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хонгорзул цахим хэлэлцүүлгийн үеэр бусад аймгуудад туршлагаасаа хуваалцжээ.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулах, батлан гаргахад зориулсан гарын авлага боловсруулж хүргүүлснээр ИТХ-уудын шийдвэр хуульд илүү нийцэх боломж бүрдлээ.

ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нарын ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр гарын авлагыг боловсруулж, энэ онд хэвлүүлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн 361 ИТХ-д хүргүүлэв. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн ИТХ захиргааны хэм хэмжээний акт боловсруулан гаргах чиглэлээр санал хэрэгжүүлсэн бөгөөд үүнд мөн тус гарын авлага тодорхой хувь нэмэр оруулсан. Тухайлбал, Дундговь аймгийн Луус, Хулд сумд “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай” тогтоолыг батлан улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-ууд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр илүү санал, санаачилга гарган ажиллаж байна.


ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх сайн туршлагыг хөхиүлэн дэмжих ээлжит тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжиж 2 аймаг, 12 сумын нийт 14 ИТХ шалгарч, хурлын үйл ажиллагаанд залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх; байгаль орчны (хог хаягдал) чиглэлээрх хяналтыг сайжруулах; ИТХ-аас захиргааны хэм хэмжээний акт боловсруулан гаргахтай холбоотой цогц үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр ажиллалаа. Тухайлбал, Захиргааны ерөнхий хуулийн дагуу ИТХ нь тухайн орон нутагтаа нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрхтэй бөгөөд заавал баримтлах процессыг хуульд тодорхой заасан. Гэсэн хэдий ч энэ талаар ялангуяа сумдын ИТХ-ын ойлголт дутмаг байна. Тэтгэлгийн хүрээнд орон нутгийн тулгамдсан асуудлын нэг болох хог хаягдалтай холбогдох асуудлыг зохицуулсан нийтээр дагаж мөрдөх журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, батлах ажил хийгдэв.

№	ИТХ	Сэдэв	Хүрэх дүр дүн
1.	Ховд аймаг	ИТХ-залуучуудын оролцоо-зэрэг хандлага	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ИТХ-аас гаргасан бодлого, хөтөлбөрт хяналт үнэлгээ, шинжилгээ хийв.
2.	Хөвсгөл аймаг	ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд ИТХ-ын хороодын хяналт тавих аргачлал	Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр ИТХ-ын “Тэргүүлэгч” гэсэн зохицуулалт байхгүй болсонтой холбоотойгоор Бодлогын хороодыг идэвхжүүлж, хяналт үнэлгээ хийх чадавхыг сайжруулав.
3.	Баянхонгор аймгийн Заг сум	Бид манлайлагч залуучууд	Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд сумын залуучуудын 15 хувь нь оролцдог. Залуучуудад мэдлэг, мэдээлэл хүргэх замаар ОНХС-ийн хэрэгжилтэд оролцоог нэмэгдүүлэв.
4.	Дорноговь аймгийн Айраг сум	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулах	Иргэдийн оролцоог хангасан, “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө” боловсруулж, хэрэгжүүлэв.
5.	Дундговь аймгийн Луус сум	Байгаль орчин бидний ирээдүй залуусын оролцоо	Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн энгийн хог хаягдлын талаар журам /захиргааны хэм хэмжээний акт/ боловсруулж, батлуулав.

6.	Дундговь аймгийн Хулд сум	ЗХХ-ний акт боловсруулахад-иргэдийн оролцоог идэвхжүүлэх нь	Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн талаар журам /захиргааны хэм хэмжээний акт/ боловсруулж, батлуулав.
7.	Завхан аймгийн Алдархаан сум	Залуучуудын оролцооны чадавхыг бэхжүүлэх	Багийн ИНХ, бусад үйл ажиллагаанд залуучуудын оролцоо 10 хувь байгааг нэмэгдүүлэх, залуучуудын оролцоотой гоор тодорхой асуудлыг шийдвэрлэв.
8.	Өмнөговь аймгийн Баяндалай сум	Хог хаягдал-иргэний оролцоо	Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийв.
9.	Төв аймгийн Алтанбулаг сум	Нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн оролцоо	Иргэдийн оролцоотойгоор бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын журам боловсруулав.
10.	Төв аймгийн Баянжаргалан сум	Эмэгтэйчүүдийн оролцоотой хяналтын механизмыг бий болгох нь	ОНХС-ийн хэрэгжилтэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэв.
11.	Төв аймгийн Баянчандмань сум	Байгаль орчинд ИТХ, бүлэг нөхөрлөлөөс хяналт тавих чадавхыг дээшлүүлэх нь	Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чадавхыг сайжруулав.
12.	Увс аймгийн Өмнөговь сум	Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо	Эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлого шийдвэрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийв.
13.	Ховд аймгийн Жаргалант сум	Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт-иргэдийн оролцоо	ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын журам боловсруулав.
14.	Хөвсгөл аймгийн Арбулаг сум	Шууд ардчилал ба залуучуудын оролцоо	ОНХС-ийн үйл ажиллагаанд залуучуудын оролцоо, хяналтыг нэмэгдүүлэв.

2020 оны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд бий болсон үр дүнгээс дурдвал:

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ИТХ Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажилласнаар 6 багийн 320 гаруй залуугийн санал 2021 онд тус сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд тусгагдсан байна. Тус сумын багуудын хэмжээнд ИНХ-д оролцох залуучуудын оролцоо нэмэгдсэний нэг жишээ нь 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд 781 иргэн хүчинтэй санал өгсний 66.6 хувь нь залуучууд байсан явдал гэж тус ИТХ-ын тайланд дурджээ.




Багийн залуучуудын хөгжлийн асуудалд анхаарч эхэлж байгаад баяртай байна. Өмнө багийн залуучуудаа хөгжүүлж, нэгтгэж хамтдаа багтаа ажил зохиож байя гэж ганц хоёр залуу яриа болгоод орхидог байсан бол энэхүү төслийн дэмжлэгтэйгээр ярьж байсан зүйл бодитой биелээд багийн залуучуудтай тулж уулзаад санал бодлоо солилцоод байгаа нь сайн байна.

Бэлбулаг 3-р багийн залуу малчин А.МӨНХГЭРЭЛ

Төрийн бус байгууллага ба ИТХ хоорондын түншлэл, хамтын ажиллагааг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрийг 5 ТББ хэрэгжүүлсэн бөгөөд хурлын хяналтын чиг үүргийг сайжруулах, Бодлогын хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр тодорхой ИТХ-уудтай хамтран ажиллав.

№	Төрийн бус байгууллагын нэр	Хамтран ажиллах ИТХ	Хүрэх үр дүн
1.	Дорнод аймгийн санхүүчдийн холбоо	Дорнод аймаг Дорнод аймгийн Хэрлэн сум	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог сайжруулан хяналт шинжилгээ хийв.
2.	Иргэдийн санаачлага-орон нутгийн хөгжил /Өвөрхангай аймаг/	Өвөрхангай аймаг Өвөрхангай аймгийн Гучин-Ус сум	ИТХ-ын ажлын хороод ажиллах арга зүй нэвтрүүлэв.
3.	Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг	Сүхбаатар дүүрэг Баянгол дүүрэг	Бодлогын хороодын үйл ажиллагаанд иргэдийн бүлгүүдийн оролцоог нэмэгдүүлэв.
4.	Монголын нутгийн удирдлагын холбоо	Төв аймаг, Төв аймгийн Алтанбулаг сум	ИТХ-ын хяналтын чиг үүргийн хүрээнд хороодыг чадавхжуулах жишиг дүрэм, журам, аргачлал боловсруулав.
5.	Нийслэлийн ажил олгогч эздийн холбоо	Багахангай дүүрэг	Дүүргийн залуучууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулах аргачлал, зөвлөмж боловсруулав.

“Дорнод аймгийн санхүүчдийн холбоо” ТББ нь тэтгэлэгт хөтөлбөрт анх удаа хамрагдсан. Дорнод аймгийн хэмжээнд шилэн дансны нэгдсэн системд шинжилгээ хийж, Шилэн дансны тухай хуулийн танилцуулга, Шилэн данс-Иргэдийн хяналт товхимол, шилэн дансны нэгдсэн цахим хуудас ашиглан мэдээлэл авах талаар гарын авлага боловсруулж, түгээснээр 2000 гаруй иргэд мэдлэг, мэдээлэлтэй болжээ.



ШИЛЭН ДАНС - ИРГЭДИЙН ХЯНАЛТ

**Шилэн дансны хуулийн тухай
иргэдийн ойлголт /санал асуулга/**

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
Дорнод аймгийн Санхүүчдын Холбоо

Иргэн танд Улсын төсвийн мэдээлэл ил тод нээлттэй байдаг уу?

Ил тод, нээлттэй

Ойлогмжгүй



ШИЛЭН ДАНС-ИРГЭДИЙН ХЯНАЛТ

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ҮНДЭСТЭЛ ШААРДЛАГА



- ✓ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1.17-д:
 - "Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцал хамаргахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй".
- ✓ Төрийн албаны тухай хуулийн 4.2.2-т:
 - "Төрийн алба ил тод байх".
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5.1.3-т:
 - "Хуулийн дагуу нууцал хамаруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх".
- ✓ Төсвийн тухай хуулийн 6.5-д:
 - "Төсвийн ил тод байдлыг хангасан байх".
- ✓ Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.1-д:
 - "Төрөөс эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны осолт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүтгэн".

Төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, тэтгэлэгт хөтөлбөр, бусад арга хэмжээний үр дүнд ИТХ-уудын чадавх нэмэгдэж байна.

Төслийн хүрээнд 2017-2019 онд зохион байгуулсан сургалт, тэтгэлэгт хөтөлбөр, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх хөндлөнгийн судалгаа хийгдэв. Судалгааг “Түгээмэл эрх, хөгжил” ТББ 2019 оны 11 дүгээр сараас 2020 оны 1 сард хийж гүйцэтгэв. Санал асуулгын судалгаанд 181 хүн биечлэн, 286 цахим хэлбэрээр, 59 хүн ярилцлагын судалгаанд хамрагдсан байна.

Судалгааны үр дүнг тоймлон дурдвал:

- Төслийн хүрээнд зохион байгуулсан бүх сургалтын үр нөлөө 80 хувиас дээш үнэлэгдсэн бөгөөд эдгээрийн дотроос эмэгтэй Төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалт болон ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө хамгийн өндөр байв.
- ИТХ болон ТББ-уудад олгосон тэтгэлгийн үр дүнд сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа ашиглах нэг ёсны практик туршилт хийх боломж болсон, ИТХ-уудын үйл ажиллагаа, чадавх сайжирсан, нутгийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын үйл ажиллагаа тогтворжсон, тэдний үйл ажиллагааны үр дүнд иргэдийн хяналтын бүлэг байгуулагдсан, иргэдийн оролцоо дээшилсэн зэрэг олон эерэг нөлөөллийг бий болгож чадсан нь судалгааны үр дүнгээр баталгаажсан байна.
- УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааг чадавхжуулах хүрээнд хийсэн ажлын үр дүнг үнэлэхэд судалгаанд оролцсон албан хаагчид эдгээр үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байсан ба Швейцарын Холбооны Улс (ШХУ)-ын парламентын төлөөлөгчидтэй хамтран боловсруулсан аргачлал үр дүнтэй байсан, нийтийн сонсгол зохион байгуулах арга, хэлбэрийг сайжруулж чадсан, хуулийн төсөлтэй холбоотой бодит, үнэн зөв, албан ёсны мэдээллийг олж авах боломжтой болсон, Монгол Улсын Үндсэн хууль, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, ЗЗНДНТУТХ-ийн хэрэгжилтэд тус тус хийсэн дүн шинжилгээ зэрэг мэдлэгийн бүтээгдэхүүнүүд байнга ашиглагддаг гэсэн үр дүнд хүрчээ.²

² “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны үр нөлөөний үнэлгээ” судалгааны тайлан. “Түгээмэл эрх хөгжил” ТББ, 2020 он

№	Үр нөлөөний үнэлгээ хийсэн төслийн үйл ажиллагаа	Үнэлгээ
1	Иргэдийн төлөөлөгчдөд зориулсан суурь сургалтын үр нөлөө	80.8
2	ИТХ-ын тэргүүлэгчдэд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	85.0
3	Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын үр нөлөө	90.0
4	Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын үр нөлөө	80.6
5	ИТХ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн үр нөлөө	75.2
Төслийн үйл ажиллагааны үр нөлөөний ерөнхий үнэлгээ		82.3

Судалгааны тайланд ИТХ-ын сонгууль бүрийн дараа энэ төрлийн сургалтыг давтан явуулдаг эрх зүйн зохицуулалт бий болгох эсвэл жишиг тогтоох; сургалтын сэдэвт хурлын үйл ажиллагаанд нөлөөлөх улс төрийн нөлөөллийг багасгах талаар тусгайлан оруулах зэргийн зөвлөмж болгосон.

ИТХ-уудын 230 сайн туршлага, сургамжаас бусад хурлууд харилцан суралцах нөхцөл бүрдлээ.

ИТХ-ын хэрэгжүүлж буй сайн туршлага, санал, санаачилгыг олж тодорхойлох, бусад хурлуудад түгээх, иргэдэд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа, ач холбогдлыг таниулах зорилго бүхий судалгааг “Эс Ай Си Эй” ХХК хийж гүйцэтгэв. Тус судалгаа нь нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумыг хамарсан. Судалгааны явцад юуны өмнө “сайн туршлага” гэж тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулсан бөгөөд ИТХ-ын өөрийн үйл ажиллагаа буюу институтын чадавх бэхжүүлэх; иргэд, олон нийтийн сайн сайхан байдалд чиглэсэн байх гэсэн суурь хоёр ангиллын хүрээнд дараах үндсэн дөрвөн үзүүлэлтийг шалгуур болгосон:

1. ИТХ-ын хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь бусад ИТХ авч хэрэгжүүлэх боломжтой байх;
2. Монгол Улсын хууль эрх зүй, үндэсний хөгжлийн бодлогод нийцсэн байх;
3. ИТХ-ын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаанд шинэ технологийг нэвтрүүлсэн байх;
4. Орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгсөн, тэдэнд хүлээн зөвшөөрөгдсөн байх.

Судалгааны хүрээнд нийт 230 гаруй ИТХ хийж хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн туршлага, санаачилгаа ирүүлснээр бусад Хуралд түгээх, танилцуулах боломжтой болж байна. Тухайлбал,

- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ нь “Мэдээллийн хөтөч” баг, “Иргэний хяналтын сайн дурын зөвлөл” байгуулан ажиллуулснаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажилд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлсэн;
- Баянхонгор аймгийн ИТХ нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Мини парламент” байгуулан ажиллуулснаар нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх хүүхдүүдийн мэдлэг ойлголт дээшилж, орон нутгийн бодлого, шийдвэрт саналыг нь тусгах болсон;
- Увс аймгийн Зүүнговь сумын ИТХ нь бэлчээрийн зохисгүй ашиглалтыг зохицуулах зорилгоор “Бэлчээр ашиглах журам” боловсруулан, сумын нийт

малчдыг 8 бүлэгт хуваан тус бүрт нийтийн сонсгол зохион байгуулж, журмыг хэлэлцүүлэн баталсан байна. Журам хэрэгжсэнээр газрын маргаан багасаж, ашиглагдахгүй байсан зах хязгаар нутагт суурьших малчдын тоо нэмэгдсэн байна.

Сайн туршлагыг www.khural.mn цахим хуудаст нийтэлж, бусад хурлуудад түгээв.

Төсөл хэрэгжих хугацаанд ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт мэдлэг орон нутагт 23 хувиар өсчээ.

ИТХ-ын талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгааг “ММСГ” судалгааны байгууллага гүйцэтгэв. Судалгаанд Улаанбаатар хотын 30 хорооноос 500 өрх, хөдөө орон нутгийн 19 сумаас 700 өрх буюу нийт 1200 өрх хамрагдсан. Өмнөх суурь судалгааны /2015 он/ үр дүнтэй харьцуулахад ИТХ-ын талаарх ойлголттой иргэдийн хувь Улаанбаатар хотод 24.8 хувиар буурч, хөдөө орон нутагт 22.8 хувиар өссөн байна.

Судалгааны зарим үр дүнгээс дурдвал:

- ИТХ-ын талаарх мэдээллийг нийт иргэдийн 86.7 хувь, үүний дотор Улаанбаатар хотын иргэдийн 85 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 87.9 хувь нь ямар нэгэн байдлаар авдаг байна.
- Аймаг, сумын ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал хөдөө орон нутагт өссөн байна. Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал 0.9 хувиар өсөж, дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал 4.5 хувиар буурсан байна.
- Аймаг, сумын ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдал хөдөө орон нутагт өссөн. Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлэх байдал 3.1 хувиар буурсан, дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдал 5.7 хувиар өссөн гэж иргэд үнэлж байна.
- ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй нийт оролцогчдын 64.1 хувь нь санал нэгдсэн байна.

Тус судалгааны тайлангийн нэгдсэн дүгнэлтэд дурдсанаар хөдөө орон нутагт ИТХ үйл ажиллагаа болон гаргасан шийдвэрээ иргэдэд тайлагнах байдал өсч, иргэдийн ойлголт мэдлэг нэмэгдсэн нь ИТХ-уудын чадавх, хандлагад өөрчлөлт гарч буйг харуулж байна. Харин нийслэл, дүүргийн хувьд эдгээр үзүүлэлт сайн өсөөгүй, буурсан байгаа нь цаашид анхаарах чиглэл болж байна.

ХҮРЭХ ҮР ДҮН 3: ОРОН НУТГИЙН СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙНГЫН МЕХАНИЗИМТАЙ БОЛОХ

Сонгогдсон Төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмыг бий болгох чиглэлээр тодорхой алхам хийгдэв.

ИТХ-ын Төлөөлөгчдөд зориулсан сургалтыг цаашид Удирдлагын академи хариуцан ажиллана. Төслийн хүрээнд өмнө зохион байгуулагдсан сургалтуудын үр дүнд, сонгогдсон Төлөөлөгчдийн үүрэг хариуцлагаа ухамсарлах, сургалтаар олж авсан мэдлэгээ ажил албандаа ашиглах байдал 80 хувьтай байна гэсэн судалгааны

дүн гарсан байдаг. Энэ нь Төслийн баримт бичигт тусгагдсан нэг зорилго биелсэний илрэл юм.

Нөгөө талаас аймгийн ИТХ-ууд уг тогтвортой байдлыг хангахад зохих хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал, 2018 онд 10 аймаг манлайллын сургалтыг хамтран санхүүжүүлсэн (нийт сургалтын зардлын 15-62 хүртэлх хувь) бол 2019 онд 21 аймаг Төлөөлөгчид болон Ажлын албаны ажилтнуудаа бататгах сургалтад хамруулж, сургалтын зардлын 67 хувийг санхүүжүүлсэн. Харин 2020 онд нийт аймаг, сумдын ИТХ-ууд 2021 оны төсвийн төсөлд чадавхжуулах сургалтын зардлыг тусгасан байна.





ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн “Төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа”-г зохицуулсан 46.2 дахь хэсэгт сургалтын төсвийг жил бүр төсөвт тусгаж байх зохицуулалтыг тусгалаа. Хуулийн төсөлд тусгагдсан энэ зохицуулалт УИХ-аар батлагдвал сонгогдсон төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах санхүүгийн эх үүсвэр баталгаатай болж, сургалтыг цаашид тогтвортой үргэлжлүүлэх боломж бүрдэх юм. 2012 болон 2016 оны орон нутгийн сонгуулийн дүнгээс харахад улс орон даяар ИТХ-д сонгогдсон 8000 гаруй төлөөлөгчийн 60% гаруй нь анх удаа шинээр сонгогдсон байсан тул ИТХ-ын төлөөлөгчдийг сургаж чадавхжуулах нь орон нутагт гарч буй шийдвэрийн хуульд нийцсэн байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль 10 дугаар сард явагдаж шинэ ИТХ бүрэлдсэнтэй холбогдуулан шинээр сонгогдсон Төлөөлөгчдийг сургах хэрэгцээ шаардлага бий болов. Энэ удаагийн сургалтыг хүлээж авсан үүргийнхээ хүрээнд Удирдлагын академи аймгийн ИТХ-уудтай хамт хамтран тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

Эмэгтэй төлөөлөгчид манлайллын сургалтаар олж авсан ур чадвар, мэдлэг туршлагаа шийдвэр гаргах түвшинд үр нөлөөтэй хэрэгжүүлж байна.

Эмэгтэй төлөөлөгчид чадавхжиж, бие биенээсээ суралцсан туршлагаа өөрийн орон нутагтаа хэрэгжүүлэн, иргэдтэйгээ илүү хамтран ажиллаж байна. Ингэснээр Төслийн “...ИТХ-ын шийдвэр, үйл ажиллагаа нь эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх” зорилтыг хангахад эерэг нөлөө үзүүлж байгаа юм.

2018 онд зохион байгуулагдсан “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын агуулгыг судалгаа, дүн шинжилгээ, манлайллын бодит түүх, жишээ кейсээр баяжуулан сургалтын гарын авлага болгон хэвлүүлж, нийт аймаг, нийслэл, сум, дүүргийн 2100 гаруй эмэгтэй Төлөөлөгчдөд түгээв. Түүнчлэн эмэгтэй төлөөлөгчдийн хүсэлт, хэрэгцээнд үндэслэн “Сошиал медиаг үр дүнтэй ашиглах нь” сэдвээр 4 цуврал цахим сургалтын агуулга боловсруулан түгээлээ. Тус сургалт нь орчин үеийн техник технологийг ашиглан олон нийттэй харилцах төлөвлөгөө боловсруулан ажиллах, мэдээллийг хүртээмжтэй байдлаар хүргэх, зөв ойлгуулах, цахим дарамтаас өөрийгөө хэрхэн хамгаалах зэрэг ур чадваруудыг олгоход чиглэж байна.



ИТХ-уудын үйл ажиллагаа, туршлага, тэдгээрийг чадавхжуулах чиглэлээр төслөөс зохион байгуулж буй арга хэмжээний талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

ЗЗНДНТУТХ-ийн төсөл, түүнд тусгагдсан онцлог асуудал, шинэ зохицуулалтын талаар телевизийн хэлэлцүүлэг, 8 богино шторк бэлтгэж түгээв. Хуулийн төслийг иргэд олон нийт, нутгийн удирдлагын байгууллагуудад хүргэх, танилцуулах зорилгоор инфографик мэдээлэл бэлтгэж хэвлүүлэн, 21 аймаг, 330 сум, 9 дүүрэгт хүргүүлэв.

Нутгийн удирдлагын тогтолцоо, нутгийн өөрөө удирдах ёс, УИХ-ын хууль тогтоох, хянан шалгах чиг үүргийг боловсронгуй болгоход чиглэсэн хууль эрх зүйн орчны өөрчлөлт, тухайлбал Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн талаар хялбаршуулсан танилцуулга, инфографик, подкаст, телевизийн ярилцлага зэргийг боловсруулах, түгээх ажил хийгдэж байна.

Эдгээр мэдлэгийн бүтээгдэхүүн, танилцуулга, мэдээллийг www.khural.mn цахим хуудас болон Төслийн SRBM Khural фэйсбүүк хуудаст нийтэлснээр зорилтот бүлэг болох Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудад хүртээмжтэй хүрч байна.



Тус төвийг хариуцсан ажилтныг 2020 онд Удирдлагын академи орон тооны ажилтан болгож, шинэ ажлын байр бий болгосон нь Төвийн цаашдын тогтвортой ажиллагааг хангасан чухал алхам боллоо.

ХҮРЭХ ҮР ДҮН 4: СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ

УИХ-ын тухай хууль тогтоомжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан нь Улсын Их Хурлаас хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчныг сайжруулахад зохих нөлөө үзүүлэв.

Төслийн 2019 он тайланд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд УИХ-ын тухай, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай зэрэг хуулиудыг нийцүүлж хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих УИХ-ын бүрэн эрх, чиг үүргийг боловсронгуй болгоход судалгаа дүн шинжилгээ, мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах³ зорилтыг тусгасан.

Энэ хүрээнд дээр дурдсан хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн баталсан Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах хэрэгцээ шаардлага бий болсон.

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө нь 2002 онд батлагдсан стратеги төлөвлөгөөнөөс стратегийн зорилт, зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээний цар хүрээний хувьд илүү өргөн агуулгатай бөгөөд Олон Улсын Парламентын Холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын зөвлөмж (Тодруулга: стратеги төлөвлөгөө боловсруулах, гадаад улс орнуудын парламентын стратеги төлөвлөгөөг орчуулах зэрэг арга зүй, судалгаа мэдээллийн бүтээгдэхүүнээр хангасан.), гадаад орнуудын парламентын стратеги төлөвлөгөөний бүтэц, загварыг судлан өөрийн орны парламентын онцлогтой нийцүүлэн шинэчилж боловсруулснаараа ач холбогдолтой болсныг цохон тэмдэглэх нь зүйтэй. Цаашид шинээр батлагдсан Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг барьж, ажил хэрэг болгож хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал.

УИХ-ын ТБХ-ны 2020.05.12-ны өдрийн хуралдаан дээр УИХ-ын гишүүн, ТБХ-ны дарга С.Бямбацогтын хэлсэн үгээс.

³ “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2019 оны тайлан.

Тайлант хугацаанд төслөөс i) УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад харьцуулсан судалгаа, мэдээллээр хангах болон ii) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэв.

Хүснэгт: УИХ-ын тухай, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гол үр дүн
1	УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хүрээнд: - Хуулийн төслийн үзэл баримтлал; - Хуулийн төсөл; - Харьцуулалт, судалгаа мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа.	Хуулийн төслийг 2018-2019 онд төслийн дэмжлэгтэйгээр хийсэн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээ, гадаад улс орнуудын (7 улс) парламентын хуралдааны дэгийн гарын авлага зэрэг харьцуулсан судалгаа, олон улсын туршлагын талаарх мэдээлэлд тулгуурлан боловсруулсан нь төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангасан бодитой үр дүн юм.
2	УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд: - Парламентат ёс; - Парламентын бүрэн эрхт байдал - Хууль тогтоох процесстэй холбоотой харьцуулсан мэдээлэл, олон улсын эх сурвалжийн орчуулга.	Хууль тогтоох, хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт, парламентын хараат бус, бие даасан байдлын баталгаа, Тамгын газрын эрх зүйн зохицуулалтыг орчин үеийн парламентын нийтлэг чиг хандлагад нийцүүлэх зорилгын хүрээнд мэдлэгийн бүтээгдэхүүнээр хангав.

Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудын хэрэгжилтэд 2018-2019 онд хийсэн дүн шинжилгээ, парламентын судлалын хүрээнд тулгамдаж буй асуудлаар 4 төрлийн томоохон судалгаа, шинжилгээ, олон улсын харьцуулсан судалгаа, мэдээллийн бүтээгдэхүүн (судалгаа, баримт бичиг орчуулах г.м)-ийг бэлтгэн хууль тогтоогчид, хуулийн төсөл боловсруулагчид, судлаачдын хүртээл болгосны үр дүнд УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн орчин боловсронгуй болж, улмаар хууль тогтоомжийн чанар, үр нөлөө дээшлүүлэх нөхцөл бүрдсэн. (Холбоотой линк: <http://parliament.mn/n/bmcy> УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлав. <http://parliament.mn/n/y9cy>, <http://parliament.mn/n/7mmo> УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлав.)

Хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр хууль тогтоогчид, Тамгын газрын ажилтнуудын мэргэшил, арга зүйн хөгжлийг дэмжихэд төслийн хүрээнд бий болсон мэдлэгийн бүтээгдэхүүнүүд хувь нэмрээ оруулж байна.

Дэлхий дахинд “Ковид 19” цар тахлын дэгдэлт өргөн хүрээг хамарч, Монгол Улсын төр засгийн байгууллагуудын шийдвэрээр олон хүн оролцсон танхимын сургалт, семинар, чадавхжуулах бусад үйл ажиллагааг хязгаарласан. Төслийн 2020 оны үйл ажиллагаанд энэ нөхцөл байдлыг харгалзан УИХ-ын Тамгын газрын ажилтнуудын мэргэшил, арга зүйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ном, гарын авлагаар хангах ажлыг хэрэгжүүлэв.



Хууль тогтоомжийн төсөл боловсруулах онол, практикийн асуудлаар мэдлэгийн бүтээгдэхүүн гаргах хүрээнд Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ээс эрхлэн гаргасан Үндсэн хууль бүтээх практикийн гарын авлага: i) Удиртгал, ii) Зарчим ба нийтлэг үндэслэл, iii) Хүний эрхийн соёлыг бий

болгох нь; iv) Хууль тогтоох эрх мэдлийн загвар, v) Гүйцэтгэх эрх мэдлийн загвар, vi) Шүүх эрх мэдлийн загвар, vii) Төвлөрлийг сааруулах хэлбэр гэсэн 7 төрлийн гарын авлагыг хэвлүүлэв.

Эдгээр ном, гарын авлагууд хууль тогтоогч, мэргэжилтнүүд, эрдэмтэн, судлаач, иргэд, олон нийтэд зориулсан судалгаа шинжилгээний эх сурвалж болоод зогсохгүй, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлж, сайжруулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой.



Мөн Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт холбогдох бусад хууль тогтоомжийн эмхэтгэл, УИХ-ын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний хялбаршуулсан танилцуулгыг хэвлүүлэв. Хууль тогтоомжийн эмхэтгэл, танилцуулга нь холбогдох эрх зүйн баримт бичгийг энгийн, ойлгомжтой байдлаар хэрэглэгчдэд хүргэж, шинэ хууль тогтоомжийн ач холбогдол, хэрэгжүүлэхэд анхаарах

зарим асуудлаар ойлголт мэдлэг өгөх юм.



Төслийн 2020 оны төлөвлөгөөнд УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд цуврал арга хэмжээ зохион байгуулах бөгөөд эхний ээлжийн сургалт,

хэлэлцүүлгийг 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав.


Сургалт, хэлэлцүүлэг нь шинээр томилогдсон эрдэм шинжилгээний ажилтнууд болон бусад судлаач, ажилтнуудын судалгаа хийх чадварыг хөгжүүлэх зорилготой бөгөөд парламентын судалгааны хүрээлэн, түүний үйл ажиллагаа, парламентын судалгааны онцлог, арга зүйн талаар илтгэл хэлэлцүүлж, асуудлаар харилцан санал солилцсон.



Сургалт, хэлэлцүүлгээс i) судалгааны арга зүй, мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах; ii) хүрээлэнгээс зохион байгуулж буй сургалтын агуулгад хууль тогтоох байгууллага болон гүйцэтгэх засаглал хоёрын хоорондын харилцааг боловсронгуй болгох асуудлыг тусгах, энэ хүрээнд Засгийн газрын гишүүдэд зориулсан сургалтыг нэмж тусгах, зохион байгуулах; iii) судлаачдыг парламентын судлалын чиглэлээр судалгааны төлбөртэй мэдээллийн сан ашиглах, судалгааны ажил гүйцэтгэхэд шаардлагатай программ хангамжаар хангах; iv) судалгааны мэдээллийн санг дижитал номын сан, эсхүл парламентын судалгааны хүрээлэнгийн цахим хуудсаар дамжуулан эргэлтэд оруулах зэрэг саналуудыг гаргаж, хэрэгжүүлж ажиллахаар тогтсон.

Хэлэлцүүлгээс гарсан санаачлагыг хэрэгжүүлэх зорилгоор Парламентын судалгааны хүрээлэнд JSTOR, Science direct зэрэг олон улсын судалгаа, мэдээллийн сан ашиглах, хууль тогтоомж, парламентын боловсролын агуулгаар богино хэмжээний видео хичээл, сурталчилгааны контент бэлтгэх (Vyond) программ хангамжийн эрх авахад нь дэмжлэг үзүүлж байна.

Төслийн дэмжлэгтэйгээр Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомж, орчин үеийн парламентын ажлын албаны нийтлэг чиг хандлагад нийцсэн Стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөртэй болов.



“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд i) УИХ-ын Тамгын газрын стратеги төлөвлөгөө; ii) УИХ-ын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан бөгөөд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 295 дугаар захирамжаар “УИХ-ын Тамгын газрын стратеги төлөвлөгөө”, дугаар захирамжаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Тамгын газрын стратеги төлөвлөгөөнд i) Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх; ii) Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд

дэмжлэг үзүүлэх; iii) Парламентын нээлттэй байдлын тунхгийг баримтлан Улсын Их Хурлын нээлттэй, ил тод байдлыг хангаж, парламентат ёсыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; iv) УИХ-ын олон нийттэй харилцах харилцааг бэхжүүлэх, иргэдэд парламентын боловсрол олгох ажлын хүртээмж, чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; v) Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх; vi) УИХ-ын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, дэд бүтцийг бүрдүүлэх, бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх; vii) УИХ-ын үйл ажиллагааны бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэх, парламентын ажлын мэргэшсэн албаны бодлого, эрх зүй, эдийн засгийн баталгаа, тогтолцоог бүрдүүлэх, чадварлаг хүний нөөцөөр хангах чиглэлээр зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, тэдгээрийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоосон.

Тамгын газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрт i) Парламентын мэргэшсэн ажлын алба-Улсын Их Хурлын Тамгын газрыг ёс зүй, цогц чадамжтай хүний нөөцөөр хангах; ii) Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлэх, хөгжүүлэх; iii) Удирдах ажилтны манлайллыг хөгжүүлэх цогц арга хэмжээ авах; iv) Парламентын мэргэшсэн ажилтан бэлтгэх, чадавхжуулах үр нөлөө бүхий сургалтын тогтолцоо бүрдүүлэх; v) Парламент судлалыг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний нэгжийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх; vii) Хүний нөөцийн удирдлагын олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг тусган 2020 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхлэв.

Стратеги төлөвлөгөө, хөтөлбөр батлагдсанаар УИХ-ын Тамгын газрын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг шинэ шатанд гаргах, хүний нөөцийн хөгжлийг хангах арга зам тодорхой болж, харилцан уялдаа холбоотой, үр нөлөө бүхий парламентын ажлын мэргэшсэн албаны тогтолцоо хөгжих нөхцөл боломж бүрдэв.

УИХ-ын Тамгын газрын стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр УИХ-ын Тамгын газрын 2019 онд хэрэгжүүлсэн онцлох 10 ажилд багтав. (Холбоотой линк: <http://parliament.mn/n/y9cy> Улсын Их Хурлын Тамгын газар хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хангалттай хэрэгжүүлж байна гэж дүгнэлээ. 2020.05.12)


Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа тогтвортой үргэлжилж, хууль

тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх журмыг батлав.

УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын парламентын Тамгын газар хоорондын 5 дахь удаагийн семинарыг 2019 оны 12 дугаар сард Швейцарын Холбооны улсын Берн хотноо зохион байгуулсан. Семинарын үеэр талууд хамтын ажиллагааны үр дүнг бататгах, цар хүрээг өргөжүүлэхэд санал нэгдсэн бөгөөд хамтран хэрэгжүүлэхээр тохирсон үйл ажиллагаагаа дараах байдлаар хэрэгжүүлж ажиллав.

УИХ-аас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын төсөл болон үнэлгээний ажилтны гүйцэтгэх ажил, үүргийн тодорхойлолтод Швейцарын парламентын Тамгын газраас санал ирүүлсэн. Холбогдох саналыг албан тушаалын тодорхойлолтод тусгаж батлан, хэрэгжүүлж ажиллаж байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх талаарх Швейцарын парламентын Тамгын газрын зохих сайн туршлага, аргачлалыг УИХ-ын Тамгын газрын бодлого, үйл ажиллагааны түвшинд нарийн уялдаа холбоотой байдлаар нутагшиж байгаагийн илрэл юм.

УИХ-аас хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх журмын төслийн талаарх хэлэлцүүлгийг хууль, УИХ-ын бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг хариуцсан УИХ-ын Тамгын газрын 10 албан тушаалтныг оролцуулан 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулав.



Тус хэлэлцүүлгээс гарсан саналыг журмын төсөлд нэмж тусган, УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 658 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх журам”-ыг батлан, хэрэгжүүлж эхлэв.

Журамд i) хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ойлголтыг нэг мөр томъёолж, ii) үнэлгээний зарчим, хамрах хүрээ, арга зүй; iii) үнэлгээний төлөвлөлт, зохион байгуулалт; iv) үнэлгээ хийх Тамгын газрын нэгжийн чиг үүрэг; v) үнэлгээний үр дүнг хянах, хэлэлцүүлэх, vi) цахим мэдээллийн сан үүсгэх, ашиглахтай холбоотой харилцааг тодорхой болгож зохицуулав.

Ингэснээр УИХ-ын Тамгын газар болон Швейцарын парламентын Тамгын газар хоорондын сүүлийн 3 жилийн хамтын ажиллагааны үр дүнд хуримтлуулсан мэдлэг, туршлага, сургамжид тулгуурлан боловсруулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийх процесс ажиллагааны албан ёсны журам, аргачлалыг бий болгож, УИХ-ын үйл ажиллагаанд шинэ практик нэвтрүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу УИХ-аас Хянан шалгах түр хороог байгуулахаар болсонтой холбогдуулан Швейцарын парламентын Мөрдөн шалгах түр хорооны үйл ажиллагааны мэдээлэл, туршлагыг судалж байна.

Энэ ажлын хүрээнд Швейцарын парламентын Мөрдөн шалгах хорооны үйл ажиллагааны чиглэл, тус хорооноос гаргасан эрх зүйн баримт бичгийн хууль зүйн хүчин чадал /шүүхэд нотлох баримт болдог эсэх/, Хяналтын хорооноос ялгаатай байдал, холбогдох баримт бичгийн мэдээлэл зэрэг асуудлаар Швейцарын парламентын Тамгын газраас мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн ирүүлсэн.

Уг мэдээлэл, танилцуулга нь УИХ-ын хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох хүрээнд гадаад улс орны жишиг, туршлагын талаарх баримтат мэдээлэл болж, хянан шалгах түр хорооны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд зохих нөлөө үзүүлж байна.

Түүнчлэн УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хамтын ажиллагааны хүрээнд 2018 онд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, тайлан гаргасан. Тэгвэл, шинээр бүрдсэн парламентын гишүүд уг тайлангийн дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын Нийгмийн бодлогын хороо, Хууль зүйн байнгын хороо болон УИХ-ын эмэгтэй гишүүд хамтран хэлэлцүүлэг зохион байгуулав. Энэ ажлын үр дүнд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх арга зүйг үйл ажиллагаандаа хэрэглэх УИХ-ын тамгын газрын хүний нөөцийн чадавх дээшилж, үнэлгээний үр дүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах жишиг тогтож байгаа юм. (Холбоотой линк: <http://www.parliament.mn/n/8xpy> Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг боллоо. 2020.09.24)



Төслийн хүрээнд нийтийн сонсгол зохион байгуулах арга зүйн сургалт, туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан УИХ-ын Тамгын газрын зөвлөх, ажилтнуудын манлайлал, идэвхтэй оролцоотойгоор Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнийг сонгон шалгаруулах томилгооны сонсголыг анх удаа зохион байгуулав. Энэ нь томилгооны сонсгол зохион байгуулах үндэслэл, журмыг холбогдох хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулж, төрийн өндөр албан тушаалтныг томилох ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зарчмыг баримтлан зохион байгуулах чиглэлээр УИХ-ын үйл ажиллагаанд гарч буй томоохон шинэчлэл болж байна.

Цаашид УИХ-ын гишүүн, түүний ажлын алба, Тамгын газрын ажилтнууд болон хууль тогтоомжийн төсөл боловсруулагчдын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт агуулга, сонгон суралцах боломжийг бүрдүүлсэн, сургалтын цахим систем бүтээж, хэрэглээнд нэвтрүүлэх, УИХ-ын Тамгын газар, Швейцарын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны үр дүнг үнэлэх, цаашдын хүрээг тодорхойлох ажлууд хийгдэнэ.

Сорилт бэрхшээл, амжилтын хүчин зүйлс ба сургамж

- ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад Төслийн зүгээс боломжит дэмжлэг тусалцааг үзүүлж байгаа хэдий ч хуулийн төсөл батлагдах нь дан ганц Төслийн хүчин чармайлтаас хамаарахгүй юм.
- Төслийн үр дүнг нутагшуулан үлдээж тогтвортой үргэлжлүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Тухайлбал, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албыг чадавхжуулах сургалтын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар ИТХ-ууд, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хандсан удаа дараагийн арга хэмжээг зохион байгууллаа. Үүний үр дүнд аймгуудын ИТХ-ууд 2021 оны төсвийн төсөлдөө сургалтын зардлыг төлөвлөж Сангийн яаманд хүргүүлээд байна. Харин 2021 оны төсвийг өмнөх оныхоос өсгөхгүйгээр боловсруулан батлуулах чиглэлийг Засгийн газраас барьж байгаатай холбоотойгоор ИТХ-уудаас боловсруулан хүргүүлсэн төсөв хасагдах эрсдэлтэй байна. Иймд 2021 онд орон нутаг төсвийн өөрийн орлого болон 2020 оны орон нутгийн төсвийн давсан орлого, дансны үлдэгдлээс санхүүжүүлэх талаар нөлөөллийн нэмэлт арга хэмжээ шаардлагатай байна. Мөн үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалан сумдын ИТХ-ын шинэ төлөөлөгчдөд зориулсан сургалтыг зохион байгуулахад Төслөөс орон нутагт тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх шаардлагатай болсон.
- ИТХ-ын үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэмжлэгийг авахаар ажиллаж байна. Энэхүү үйл явц 3 жил үргэлжилж байгаа боловч ахиц гарахгүй байгааг анхаарч, ИТХ-ын үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ойрын хугацаанд нутагшуулах хэрэгтэй байна.
- ИТХ-ын үлгэрчилсэн дэгийг батлуулах зорилгоор ИТХ-уудтай шууд харилцаж, хамтран ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч хуралдааны дэгээ шинэчлэн баталж байгаа тоо эрс нэмэгдлээ.
- Бусад улс орныхтой ижил дагнасан яам зэрэг хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд орон нутгийн дуу хоолой, эрх ашгийг төлөөлөх бүтэц тогтолцоо төв засгийн газрын түвшинд одоогоор байхгүй байна. Энэ асуудлыг ЗЗНДНТУХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулаад байна. Хууль батлагдсан, эс батлагдсан аль ч тохиолдолд төв засгийн газрын түвшинд орон нутгийн асуудлыг ойлгож, ижил түвшинд эрх ашгийг нь хүлээн зөвшөөрч харилцах хандлага, ойлголтыг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага оршсоор байгааг ИТХ-ууд илэрхийлж байна.

ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ

- Төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төслийн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж-баталсан.
- Төслийн 2020 оны батлагдсан төсөв 750,000 доллар, 11 дүгээр сарын 30-ны байдлаар зарцуулалт 430,000 доллар буюу 57% байна. Төслийн санхүүгийн нийт гүйцэтгэлийг хүснэгтээр харуулвал:

Хүрэх үр дүн	Зарцуулалт			2020 оны гүйцэтгэл /11 сарын 30-ны байдлаар/	Нийт /үр дүн тус бүрээр/	Төслийн баримт бичигт заасан дүнтэй харьцуулсан %
	2017	2018	2019			
	гүйцэтгэл	гүйцэтгэл	гүйцэтгэл			
Үр дүн 1.	38,047.00	73,691.00	140,920.00	56,029.00	308,687.00	91%
Үр дүн 2.	79,741.00	121,857.00	188,102.00	119,581.00	509,281.00	80%
Үр дүн 3.	714,327.00	414,656.00	252,947.00	85,258.00	1,467,188.00	97%
Үр дүн 4.	46,764.00	116,764.00	150,296.00	49,219.00	363,043.00	79%
Үр дүн 5.	98,479.00	102,681.00	103,055.00	74,646.58	378,862.00	69%
GMS	52,164.00	60,164.00	62,843.00	30,897.00	206,068.00	84%
Нийт /оноор/	1,029,522.00	889,813.00	898,163.00	415,631.00		
Нийлбэр					3,233,129.00	
Төслийн баримт бичигт заасан					3,800,000.00	
Бодит төсөв (3,135,000 швейцар франк нь 3,141,000 доллар болж хөрвөсөн байна)					3,641,993.49	

- УИХ-ын Тамгын газар нь Төслийн үндэсний хамтран хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд төслийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд УИХ-ын Тамгын газар хариуцахаар тусгагдсан үйл ажиллагаанууд, тухайлбал худалдан авалтад дотоодын хуулийн зохицуулалтыг баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд худалдан авалттай холбоотой Үнэлгээний хороонд Тамгын газрын ажилтнууд томилогдон ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар гэрээт ажлын гүйцэтгэлийг хүлээн авах үүрэг бүхий 4 ажлын хэсэг, тендерийн хуулийн дагуу худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх 2 үнэлгээний хороо байгуулагдсан байна. Эдгээр ажлын хэсэг, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төслийн ажилтнууд орж, бичиг баримт боловсруулах, хурал зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх үүрэгтэй нарийн бичгийн даргаар ажиллалаа.
- Шилэн дансны цахим хуудаст төслийн үйл ажиллагаатай холбоотой 24 төрлийн мэдээллийг тухай бүр нийтэлж, олон нийтэд нээлттэй байх зарчмыг хангаж байна.